

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2025/007/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Оргилмөрөн
Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.25 № 80
танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-
ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ш.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангийн хугацаанд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, байгаль хамгаалах зардлын санхүүжилт 13,777,576.7 мянган төгрөг үндсэн дансанд, нэмэлт дансаар 392,426.3 мянган төгрөг бүрдүүлэн зардлын зүйл ангиар зарцуулж хэмнэлтийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Тайлант онд байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр хийгдсэн 10 ажлын тендерийн баталгааны 103,772.8 мянган төгрөгийг өглөг нэмж бүртгэсэн байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

Аудитын гол асуудал

Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 34.1 хувиар өссөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг 3,205,375.2 мянган төгрөг, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлыг 4,107,200.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Бусад асуудал

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 2024 оны гүйцэтгэлийг төлөвлөгөөг 13 зорилт б5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай байгуулж байгуулж, хэрэгжилтийг 95.3 хувьтай үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,847,795,588.00	1,461,449,387.20
33	АВЛАГА	599,840,000.00	569,840,000.00
335	Бусад авлага	599,840,000.00	569,840,000.00
3351	Байгууллагаас авах авлага	599,840,000.00	569,840,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,247,955,588.00	891,609,387.20
351	Түүхий эд материал	5,166,543,150.00	749,868,137.20
35110	Тусгай зориулалттай материал	5,166,543,150.00	749,868,137.20
354	Хангамжийн материал	81,412,438.00	141,741,250.00
35410	Бичиг хэргийн материал	4,922,600.00	6,807,650.00
35420	Аж ахуйн материал	26,489,838.00	84,933,650.00
35470	Бусад хангамжийн материал	50,000,000.00	49,999,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,234,113,515.26	20,279,471,020.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,234,113,515.26	20,279,471,020.24
392	Биет хөрөнгө	17,804,371,952.76	19,745,362,082.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,852,055,985.02	16,841,039,280.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,878,625,539.30	-2,649,362,351.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	220,134,800.00	240,069,082.12
39204	Хуримтлагдсан элэгдэл	-192,840,008.27	-219,362,503.87
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,266,438,765.91	3,061,352,892.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,269,600,824.12	-1,644,689,729.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	631,942,906.18	1,188,469,774.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	-275,720,933.01	-325,278,049.31
39209	Зам, гүүрийн байгууламж	4,289,846,690.51	4,958,117,300.83
39210	Хуримтлагдсан элэгдэл	-839,259,890.16	-1,704,993,613.74
393	Биет бус хөрөнгө	429,741,562.50	534,108,937.50
39301	Програм хангамж	59,815,000.00	63,565,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-23,453,437.50	-36,326,062.50
39303	Бусад биет бус хөрөнгө	393,380,000.00	506,870,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	24,081,909,103.26	21,740,920,407.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	675,905,331.00	682,699,407.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	675,905,331.00	682,699,407.92
413	Өглөг	675,905,331.00	682,699,407.92
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	347,841.92
4136	Бусад өглөг	675,905,331.00	682,351,566.00
41361	Байгууллагад төлөх өглөг	675,905,331.00	682,351,566.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	23,406,003,772.26	21,058,220,999.52
51	Засгийн газрын хувь оролцоо	23,406,003,772.26	21,058,220,999.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,729,095,366.14	1,729,095,366.14
51101	Өмч: - төрийн	1,729,095,366.14	1,729,095,366.14
512	Хуримтлагдсан үр дүн	21,222,394,673.49	18,874,611,900.75
51210	Өмнөх үеийн үр дүн	21,222,394,673.49	21,222,394,673.49
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-2,347,782,772.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	454,513,732.63	454,513,732.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	24,081,909,103.26	21,740,920,407.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	16,432,003,453.73	18,981,206,071.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,024,405,453.73	4,841,203,057.46
120	Нийтлэг татварын бус орлого	9,024,405,453.73	4,841,203,057.46
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,418,253,453.73	4,124,268,807.26
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,606,152,000.00	716,934,250.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,407,598,000.00	14,140,003,014.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	687,203,000.00	362,426,314.19
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	672,418,000.00	332,355,425.00
131105	Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,785,000.00	30,070,889.19
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	6,720,395,000.00	13,777,576,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	6,720,395,000.00	13,777,576,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,792,674,374.23	19,180,093,787.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,792,674,374.23	19,180,093,787.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,233,828,216.08	16,866,071,019.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,703,928,454.56	4,968,018,859.13
210101	Үндсэн цалин	1,946,443,907.58	2,903,794,837.15
210102	Нэмэгдэл	854,421,059.91	1,152,022,624.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	378,402,391.74	390,887,313.11
210104	Урамшуулал	93,630,034.93	141,949,935.12
210105	Гэрээт ажлын хөлс	431,031,060.40	379,364,148.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	468,154,336.45	642,249,691.92
210201	Тэтгэврийн даатгал	325,075,462.17	448,239,945.20
210202	Тэтгэмжийн даатгал	37,111,567.58	50,037,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,315,254.39	40,030,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,892,961.97	17,100,477.10
210205	Эрүүл мэндийн даатгал	69,759,090.34	86,841,769.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,202,235.71	227,816,909.79
210301	Гэрэл, цахилгаан	87,663,049.37	92,240,623.19
210302	Түлш, халаалт	67,158,211.57	76,339,237.31
210303	Цэвэр, бохир ус	48,852,974.77	59,237,049.29
210304	Байрны түрээс	528,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	321,162,130.13	229,240,059.60
210401	Бичиг хэрэг	98,772,410.00	138,604,500.00
210402	Тээвэр, шатахуун	155,757,000.00	36,169,975.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,875,070.13	29,601,568.70
210404	Ном, хэвлэл	5,722,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	650,000.00	1,999,965.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,385,650.00	22,864,050.00
2105	Нормативт зардал	1,200,000.00	0.00
210502	Хоол, хүнс	1,200,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,287,700.00	77,255,940.00
210602	Тавилга	0.00	1,130,160.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,200,000.00	5,060,000.00
210604	Урсгал засвар	52,087,700.00	71,065,780.00
2107	Томилолт, зочны зардал	2,876,700.00	3,256,440.00
210702	Дотоод албан томилолт	2,876,700.00	3,256,440.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	875,100,864.00	8,425,304,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	844,738,091.00	8,389,808,839.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3,333,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,600,810.00	3,831,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	745,275.00	1,632,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	122,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,775,700.00	5,000,000.00
210807	Газрын төлбөр	21,240,988.00	21,577,181.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,602,915,795.23	2,292,928,399.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,657,248.00	30,753,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,994,000.00	9,999,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,570,264,547.23	2,252,174,749.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	558,846,158.15	2,314,022,767.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,505,189.00	319,852,133.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	21,900,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,184,300.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,523,400.00	11,673,381.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	121,755,782.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	55,797,489.00	164,522,970.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	468,340,969.15	1,994,170,634.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	468,340,969.15	1,975,520,867.48
213404	Хөрөнгийн		18,649,767.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,639,329,079.50	-198,887,715.74
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	367,783,241.60	2,148,895,057.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	44,699,617.60	0.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	323,083,624.00	2,148,895,057.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-367,783,241.60	-2,148,895,057.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,271,545,837.90	-2,347,782,772.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,407,598,000.00	14,170,003,014.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,407,598,000.00	14,170,003,014.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	687,203,000.00	392,426,314.19
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	672,418,000.00	332,355,425.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,785,000.00	60,070,889.19
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	6,720,395,000.00	13,777,576,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	6,720,395,000.00	13,777,576,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,012,490,633.00	11,478,877,688.19

21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,012,490,633.00	11,478,877,688.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,451,752,474.85	9,134,404,920.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,703,928,454.56	4,968,018,859.13
210101	Үндсэн цалин	1,946,443,907.58	2,903,794,837.15
210102	Нэмэгдэл	854,421,059.91	1,152,022,624.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	378,402,391.74	390,887,313.11
210104	Урамшуулал	93,630,034.93	141,949,935.12
210105	Гэрээт ажлын хөлс	431,031,060.40	379,364,148.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	468,154,336.45	641,901,850.00
210201	Тэтгэврийн даатгал	325,075,462.17	447,892,103.28
210202	Тэтгэмжийн даатгал	37,111,567.58	50,037,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,315,254.39	40,030,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,892,961.97	17,100,477.10
210205	Эрүүл мэндийн даатгал	69,759,090.34	86,841,769.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,202,235.71	227,816,909.79
210301	Гэрэл, цахилгаан	87,663,049.37	92,240,623.19
210302	Түлш, халаалт	67,158,211.57	76,339,237.31
210303	Цэвэр, бохир ус	48,852,974.77	58,709,049.29
210304	Байрны түрээс	528,000.00	528,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	323,599,530.13	220,912,109.60
210401	Бичиг хэрэг	101,839,810.00	130,666,550.00
210402	Тээвэр, шатахуун	155,127,000.00	35,779,975.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,875,070.13	29,601,568.70
210404	Ном, хэвлэл	5,722,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	650,000.00	1,999,965.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,385,650.00	22,864,050.00
2105	Нормативт зардал	1,200,000.00	0.00
210502	Хоол, хүнс	1,200,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,778,100.00	86,125,740.00
210602	Тавилга	13,498,400.00	9,999,960.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,200,000.00	5,060,000.00
210604	Урсгал засвар	52,079,700.00	71,065,780.00
2107	Томилолт, зочны зардал	2,876,700.00	3,256,440.00
210702	Дотоод албан томилолт	2,876,700.00	3,256,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	645,619,870.00	2,945,619,362.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	614,532,797.00	2,910,123,481.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3,333,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,600,810.00	3,831,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	745,275.00	1,632,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	122,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,500,000.00	5,000,000.00
210807	Газрын төлбөр	21,240,988.00	21,577,181.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,393,248.00	40,753,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,399,248.00	30,753,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,994,000.00	9,999,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	560,738,158.15	2,344,472,767.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,397,189.00	320,302,133.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	21,900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,523,400.00	11,673,381.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	121,755,782.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	57,689,489.00	164,972,970.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	468,340,969.15	1,994,170,634.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	468,340,969.15	1,994,170,634.67
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	30,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	30,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,395,107,367.00</u>	<u>2,691,125,326.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,395,107,367.00	2,691,125,326.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,395,107,367.00	2,691,125,326.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,395,107,367.00	2,691,125,326.00
220001	Барилга байгууламж	1,025,505,198.00	1,902,593,212.00
222001	Тоног төхөөрөмж	28,000,000.00	673,819,350.00
223001	Бусад хөрөнгө	341,602,169.00	114,712,764.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-1,395,107,367.00</u>	<u>-2,691,125,326.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
9	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,729,095,366.14	465,095,727.43	13,023,656,840.79	15,217,847,934.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-72,808,005.20	-72,808,005.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,729,095,366.14	465,095,727.43	12,950,848,835.59	15,145,039,929.16
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-10,581,994.80	0.00	-10,581,994.80
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	8,271,545,837.90	8,271,545,837.90
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,729,095,366.14	454,513,732.63	21,222,394,673.49	23,406,003,772.26
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,729,095,366.14	454,513,732.63	21,222,394,673.49	23,406,003,772.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,729,095,366.14	454,513,732.63	21,222,394,673.49	23,406,003,772.26
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-2,347,782,772.74	-2,347,782,772.74
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,729,095,366.14	454,513,732.63	18,874,611,900.75	21,058,220,999.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,110,172,600.00	11,802,055,832.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,722,807,300.00	9,110,930,506.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,368,201,900.00	8,836,333,373.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,903,746,600.00	4,903,536,562.13
210101	Үндсэн цалин	1,863,111,200.00	2,903,794,837.15
210102	Нэмэгдэл	1,309,621,000.00	1,152,022,624.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	405,014,400.00	390,887,313.11
210104	Урамшуулал	0.00	141,949,935.12
210105	Гэрээт ажлын хөлс	1,326,000,000.00	314,881,851.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	634,252,600.00	634,252,600.00
210201	Тэтгэврийн даатгал	425,318,500.00	440,242,853.28
210202	Тэтгэмжийн даатгал	50,037,500.00	50,037,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	40,030,000.00	40,030,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	10,007,500.00	17,100,477.10
210205	Эрүүл мэндийн даатгал	108,859,100.00	86,841,769.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	335,629,100.00	227,816,909.79
210301	Гэрэл, цахилгаан	153,612,600.00	92,240,623.19
210302	Түлш, халаалт	88,162,500.00	76,339,237.31
210303	Цэвэр, бохир ус	83,854,000.00	58,709,049.29
210304	Байрны түрээс	10,000,000.00	528,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	178,234,000.00	178,142,109.60
210401	Бичиг хэрэг	78,000,000.00	93,796,550.00
210402	Тээвэр, шатахуун	30,000,000.00	29,999,975.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,369,000.00	29,481,568.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,999,965.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,865,000.00	22,864,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	86,126,000.00	86,125,740.00
210602	Тавилга	10,000,000.00	9,999,960.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,060,000.00	5,060,000.00
210604	Урсгал засвар	71,066,000.00	71,065,780.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	3,256,440.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	3,256,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,184,453,600.00	2,762,449,362.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,140,069,900.00	2,726,953,481.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	3,333,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,831,500.00	3,831,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,632,200.00	1,632,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	672,000.00	122,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	5,000,000.00
210807	Газрын төлбөр	23,248,000.00	21,577,181.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,760,000.00	40,753,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,760,000.00	30,753,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	9,999,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	354,605,400.00	274,597,133.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	354,605,400.00	274,597,133.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,900,000.00	21,900,000.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,673,400.00	11,673,381.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	194,802,000.00	121,755,782.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	126,230,000.00	119,267,970.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,387,365,300.00	2,691,125,326.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,387,365,300.00	2,691,125,326.00
220001	Барилга байгууламж	3,545,665,300.00	1,902,593,212.00
222001	Тоног төхөөрөмж	692,000,000.00	673,819,350.00
223001	Бусад хөрөнгө	149,700,000.00	114,712,764.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,110,172,600.00	11,802,055,832.52
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,984,035,800.00	11,802,055,832.52
132001	Орон нутгийн төсвөөс	10,984,035,800.00	11,802,055,832.52
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	264.00	264.00
620001	Удирдах ажилтан	29.00	29.00
620002	Гүйцэтгэх ажилтан	77.00	77.00
620003	Үйлчлэх ажилтан	28.00	28.00
620004	Гэрээт ажилтан	130.00	130.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	264.00	264.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	78.00	78.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	28.00	28.00
650010	Гэрээт ажилтан	130.00	130.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	28.00	28.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	687,203,000.00	392,426,314.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	687,203,000.00	392,426,314.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	644,000,580.32	298,071,547.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,497,036.00	64,482,297.00
210104	Урамшуулал	437,480.00	
210105	Гэрээт ажлын хөлс	61,059,556.00	64,482,297.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,864,997.32	7,649,250.00
210201	Тэтгэврийн даатгал	6,864,997.32	7,649,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	165,040,800.00	50,110,000.00
210401	Бичиг хэрэг	38,613,800.00	44,210,000.00
210402	Тээвэр, шатахуун	126,327,000.00	5,780,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	120,000.00
2105	Нормативт зардал	1,200,000.00	0.00
210502	Хоол, хүнс	1,200,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,000.00	0.00
210604	Урсгал засвар	250,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	409,147,747.00	175,830,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	409,147,747.00	175,830,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,716,500.00	45,705,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,716,500.00	45,705,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,716,500.00	45,705,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,485,919.68	48,649,767.19
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,485,919.68	18,649,767.19
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	30,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	687,203,000.00	392,426,314.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	687,203,000.00	392,426,314.19
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	675,188,634.00	332,355,425.00
131105	Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,014,366.00	60,070,889.12

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 119,629.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 12,639.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 97,858.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 9,132.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

Урамшууллаас хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, ажил олгогчоос олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн мөнгийг давхардуулан илүү олгосон зэрэг 12,639.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

Улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад балансын урамшуулал, нийт албан хаагчдад аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нэмэлт урамшуулал улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон зөрчилд 97,858.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага өглөө.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 80802 /ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал/ зориулалт арга хэмжээний 213204 - ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал зардлын 8,784.3 мянган төгрөгийг 83201 /Ангилагдаагүй бусад/ зориулалт арга хэмжээний 213204 - ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардалд зарцуулах эрхийг нээж тэтгэмжийн зардлыг тус дүнгээр өөр өөр зориулалт арга хэмжээнээс хувааж гаргасан, мөн үүнтэй холбоотойгоор урсгал санхүүжилтийг нийт 8,784.3 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам"-ын 4.4-д "Сум, дүүргийн төрийн сан нь Засаг даргын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу сум, дүүргийн төсвийн байгууллагын санхүүжилтийн эрхийн тооцоог хийж санхүүжилтийг сар бүрийн ажлын эхний 5 өдөрт багтаан ЗЭБ№1 маягтаар, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт орсноос хойш

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажлын 1 өдөрт багтаан ЗЭБ№1 маягтаар тус тус баталгаажуулан дүүргийн төрийн сангийн мэргэжилтэн, сумын төрийн сангийн төлөөлөгч нар олгоно", 5.4-д "Төсвийн байгууллага нь зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллын дагуу зардал гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн өр, төлбөр үүсгэхгүйгээр хөтөлбөр, арга хэмжээний зорилтыг бүрэн хангахаар төсвийг зарцуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтыг эрхийг батлагдсан төсөвт үндэслэн нээж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, санхүүгийн ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлэх.

2. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн 347.8 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох өр төлбөрийг бүрэн хянаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, үйл ажиллагааны урсгал зардалтай холбоотой өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар	1	12,175.6	1	12,175.6								
	1	463.6	1	463.6								
	1	94,935.4			1	94,935.4						
	1	2,923.0			1	2,923.0						
	1	8,784.3					1	8,784.3				
	1	347.8					1	347.8				
Дүн	6	119,629.7	2	12,639.2	2	97,858.4	2	9,132.1				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1			1				
	НИЙТ	1	1			1				